



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СБА-2022/22/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт

2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Захирал: А.Сарангэрэл

Утас: 9988 4842

Цахим хаяг: gereltekhburtgelaudit03@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|----|
| Товчилсон үгийн жагсаалт..... | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 6 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 8 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 8 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 10 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 11 |
| 3. Аудитын тайлан..... | 12 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 12 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 12 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 13 |
| 3.4 Материаллаг байдал | 13 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 13 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 14 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... | 15 |
| 3.8 Аудитын гол асуудал | 15 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 15 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 15 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 16 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 16 |
| 4. Аудитын илрүүлэлт | 16 |
| 4.1 Залруулсан алдаа | 16 |
| 4.2 Албан шаардлага | 16 |
| 4.3 Зөвлөмж..... | 17 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠑᠙᠘᠘.᠐᠘.᠒5 № 45
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ШҮҮХИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА
Г.ИДЭРБАТ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>2,804,580.00</u> | <u>2,747,900.00</u> |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 2,804,580.00 | 2,747,900.00 |
| 351 | Түүхий эд материал | 1,846,600.00 | 1,714,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 127,000.00 | 127,000.00 |
| 35130 | Эм боох материал | 1,719,600.00 | 1,587,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 957,980.00 | 1,033,900.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 210,080.00 | 123,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 80,900.00 | 80,900.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 360,000.00 | 487,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 36,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 307,000.00 | 307,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>208,401,500.06</u> | <u>200,921,004.51</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 208,401,500.06 | 200,921,004.51 |
| 392 | Биет хөрөнгө | 201,101,500.06 | 181,906,004.51 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 151,988,950.00 | 151,988,950.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (8,155,765.52) | (12,368,398.88) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 53,900,000.00 | 31,900,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (32,633,333.44) | (15,950,000.16) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 48,739,932.40 | 48,739,932.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (17,042,324.08) | (25,947,461.43) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 7,748,214.29 | 7,748,214.29 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (3,444,173.59) | (4,205,231.71) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,075,000.00 | 6,075,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (6,075,000.00) | (6,075,000.00) |
| 393 | Биет бус хөрөнгө | 7,300,000.00 | 19,015,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,300,000.00 | 19,015,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>211,206,080.06</u> | <u>203,668,904.51</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>211,206,080.06</u> | <u>203,668,904.51</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 211,206,080.06 | 203,668,904.51 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 125,499,500.00 | 125,499,500.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 125,499,500.00 | 125,499,500.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 84,289,453.18 | 76,752,277.63 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 84,289,453.18 | 84,289,453.18 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (7,537,175.55) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,417,126.88 | 1,417,126.88 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>211,206,080.06</u> | <u>203,668,904.51</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 162,861,541.18 | 185,343,600.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 47,255,241.18 | 15,492,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 40,786,441.18 | 15,492,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,478,600.00 | 3,777,000.00 |

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,478,600.00 | 3,777,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 35,307,841.18 | 11,715,000.00 |
| 122 | Тусламжийн орлого | 6,468,800.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 6,468,800.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 115,606,300.00 | 169,851,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 114,906,300.00 | 165,684,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 114,906,300.00 | 165,684,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 700,000.00 | 4,166,800.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 700,000.00 | 2,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 2,166,800.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 120,285,250.93 | 192,880,775.55 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 120,285,250.93 | 192,880,775.55 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 120,285,250.93 | 192,015,220.55 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 86,846,850.00 | 139,220,474.00 |
| 210101 | Үндсэн цалин | 48,706,372.00 | 91,659,719.00 |
| 210102 | Нэмэгдэл | 32,184,150.00 | 40,667,566.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,956,328.00 | 6,893,189.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,276,315.00 | 3,088,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,981,092.00 | 309,489.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 94,823.00 | 8,199.87 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 75,858.00 | 6,559.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,964.00 | 1,639.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,105,578.00 | 2,762,610.70 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,229,965.00 | 12,637,818.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 674,585.00 | 849,950.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,069,840.00 | 10,700,328.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 485,540.00 | 1,087,540.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,456,664.00 | 6,445,230.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,029,638.00 | 2,076,340.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,338,610.00 | 2,672,020.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 534,100.00 | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 554,316.00 | 696,870.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,347,570.00 | 1,852,320.00 |
| 210501 | Эм | 1,347,570.00 | 1,852,320.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,482,850.00 | 3,710,210.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 354,500.00 | 489,410.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,128,350.00 | 3,220,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,172,000.00 | 1,896,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,172,000.00 | 1,896,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,011,876.00 | 3,969,173.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,138,586.00 | 3,599,468.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 149,500.00 | 150,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 120,000.00 | 120,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 20,000.00 |

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|----------------------|-----------------------|
| 210807 | Газрын төлбөр | 43,790.00 | 79,705.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,461,160.93 | 19,195,495.55 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 10,461,160.93 | 19,195,495.55 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 865,555.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 865,555.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 865,555.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 42,576,290.25 | (7,537,175.55) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 42,576,290.25 | (7,537,175.55) |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 123,743,500.00 | 1,417,126.88 | 58,629,207.38 | 183,789,834.26 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 123,743,500.00 | 1,417,126.88 | 58,629,207.38 | 183,789,834.26 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 1,756,000.00 | - | 42,576,290.25 | 44,332,290.25 |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 125,499,500.00 | 1,417,126.88 | 84,289,453.18 | 211,206,080.06 |
| D01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 125,499,500.00 | 1,417,126.88 | 84,289,453.18 | 211,206,080.06 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 125,499,500.00 | 1,417,126.88 | 84,289,453.18 | 211,206,080.06 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (7,537,175.55) | (7,537,175.55) |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 125,499,500.00 | 1,417,126.88 | 76,752,277.63 | 203,668,904.51 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 155,882,800.00 | 173,628,600.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 7,212,600.00 | 3,777,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,212,600.00 | 3,777,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7,212,600.00 | 3,777,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,212,600.00 | 3,777,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 148,670,200.00 | 169,851,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 147,970,200.00 | 165,684,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 147,970,200.00 | 165,684,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 700,000.00 | 4,166,800.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 700,000.00 | 2,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 2,166,800.00 |

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 155,882,800.00 | 173,628,600.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 155,882,800.00 | 173,628,600.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 154,768,459.00 | 172,763,045.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 120,430,769.00 | 139,220,474.00 |
| 210101 | Үндсэн цалин | 71,101,490.00 | 91,659,719.00 |
| 210102 | Нэмэгдэл | 41,346,794.00 | 40,667,566.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,982,485.00 | 6,893,189.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,472,347.00 | 3,088,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,408,306.00 | 309,489.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 145,084.00 | 8,199.87 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 116,067.00 | 6,559.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 29,017.00 | 1,639.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,773,873.00 | 2,762,610.70 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 12,146,845.00 | 12,637,818.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 888,965.00 | 849,950.00 |
| 210302 | Түлш, халаалт | 10,621,860.00 | 10,700,328.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 636,020.00 | 1,087,540.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,256,302.00 | 6,485,150.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,786,896.00 | 1,989,260.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,259,310.00 | 2,799,020.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 792,700.00 | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,417,396.00 | 696,870.00 |
| 2105 | Нормативт зардал | 2,344,320.00 | 1,819,720.00 |
| | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,344,320.00 | 1,819,720.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,918,010.00 | 3,746,210.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 467,380.00 | 489,410.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,450,630.00 | 3,256,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,964,000.00 | 1,896,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,964,000.00 | 1,896,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,235,866.00 | 3,869,173.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,326,816.00 | 3,499,468.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 149,500.00 | 150,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 120,000.00 | 120,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 20,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 79,550.00 | 79,705.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,114,341.00 | 865,555.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,114,341.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,114,341.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 865,555.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 865,555.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|-----------------------|---|-----------------------|-----------------------|-------------------|---------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 168,984,800.00 | 168,596,245.00 | 388,555.00 | 99.77 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 168,984,800.00 | 168,596,245.00 | 388,555.00 | 99.77 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 168,984,800.00 | 168,596,245.00 | 388,555.00 | 99.77 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 139,224,300.00 | 139,220,474.00 | 3,826.00 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 85,472,500.00 | 91,659,719.00 | (6,187,219.00) | 107.24 |
| 210102 | Нэмэгдэл | 42,303,800.00 | 40,667,566.00 | 1,636,234.00 | 96.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,448,000.00 | 6,893,189.00 | 4,554,811.00 | 60.21 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,088,500.00 | 3,088,500.00 | 0.00 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 309,489.56 | (309,489.56) | - |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 8,199.87 | (8,199.87) | - |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 6,559.90 | (6,559.90) | - |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 1,639.97 | (1,639.97) | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,088,500.00 | 2,762,610.70 | 325,889.30 | 89.45 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 12,992,000.00 | 12,637,818.00 | 354,182.00 | 97.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 900,000.00 | 849,950.00 | 50,050.00 | 94.44 |
| 210302 | Түлш, халаалт | 10,912,000.00 | 10,700,328.00 | 211,672.00 | 98.06 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,180,000.00 | 1,087,540.00 | 92,460.00 | 92.16 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,490,000.00 | 6,485,150.00 | 4,850.00 | 99.93 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,990,000.00 | 1,989,260.00 | 740.00 | 99.96 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,800,000.00 | 2,799,020.00 | 980.00 | 99.97 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 700,000.00 | 696,870.00 | 3,130.00 | 99.55 |
| 2105 | Нормативт зардал | 1,820,000.00 | 1,819,720.00 | 280.00 | 99.98 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,820,000.00 | 1,819,720.00 | 280.00 | 99.98 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 680,000.00 | 679,410.00 | 590.00 | 99.91 |

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | |
|---------------|--|-----------------------|-----------------------|---------------------|---------------|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 490,000.00 | 489,410.00 | 590.00 | 99.88 |
| 210604 | Урсгал засвар | 190,000.00 | 190,000.00 | - | 100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,900,000.00 | 1,896,000.00 | 4,000.00 | 99.79 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,900,000.00 | 1,896,000.00 | 4,000.00 | 99.79 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,790,000.00 | 2,769,173.00 | 20,827.00 | 99.25 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,400,000.00 | 2,399,468.00 | 532.00 | 99.98 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 150,000.00 | 150,000.00 | - | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 120,000.00 | 120,000.00 | - | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 20,000.00 | - | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 100,000.00 | 79,705.00 | 20,295.00 | 79.71 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 168,984,800.00 | 169,461,800.00 | (477,000.00) | 100.28 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 165,684,800.00 | 165,684,800.00 | - | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 165,684,800.00 | 165,684,800.00 | - | 100.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 3,300,000.00 | 3,777,000.00 | (477,000.00) | 114.45 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,300,000.00 | 3,777,000.00 | (477,000.00) | 114.45 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 8 | 8 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 7 | 7 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | - | - | - | - |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант он |
|-----------------------|---|---------------------|
| | | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,166,800.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,166,800.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,166,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,066,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,066,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,100,000.00 |

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | |
|-------------|---|---------------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,100,000.00 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 4,166,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,166,800.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,166,800.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 8 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 7 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовын туслах Э.Алтангэрэл, аудиторовын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 130/09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах үйл ажиллагаа явуулдаг, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 3,439.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,751.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль, Төрийн болон орон нутгийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------------|----------------|-----------------|-----------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 2,804.6 | 2,747.9 | (56.7) |
| Үндсэн хөрөнгө | 208,401.5 | 200,921.0 | (7,480.0) |
| Нийт хөрөнгө | 211,206.1 | 203,668.9 | (7,537.2) |

| | | | |
|---|------------------|------------------|------------------|
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 211,206.1 | 203,668.9 | (7,537.2) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 211,206.1 | 203,668.9 | (7,537.2) |

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 200,921.0 мянган төгрөг болж, 7,480.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Үндсэн хөрөнгийн данс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А-1/1937 дугаартай албан тоотын дагуу үнэ төлбөргүй шилжин ирсэн 2,343 м.кв талбайтай, эзэмших эрхтэй газрын 11,715.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн, СБА 19-99 улсын дугаартай, Тоёота ланд круйзер-80 маркийн автомашиныг актлан данснаас хассаны 22,000.00 мянган төгрөгийн дүнгээр буурчээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 22,482.1 мянган төгрөгөөр буюу 14 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Энэ нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оны мөн үеэс 50,778.5 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 72,595.5 мянган төгрөгөөр буюу 60.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшилтай холбоотой зардал байна. Энэ нь цалингийн зардал өмнөх оны мөн үеэс 88.2 хувиар нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 175,508.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 170,008.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 6,523.3 мянган төгрөгөөр бууруулж 168,984.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 52 арга хэмжээг санхүүжүүлэхээр 168,984.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 165,684.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр, 3,300.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 165,684.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,777.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 168,596.2 мянган төгрөгийг зарцуулж, 865.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 2,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт 2,166.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бараа үйлчилгээний зардалд 4,166.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А-1/1937 дугаартай албан тоотын дагуу үнэ төлбөргүй шилжин ирсэн 2,343 м.кв талбайтай, эзэмших эрхтэй газрын 11,715.0 мянган төгрөгийг тайлагнасан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Нийт 8 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 2,385.9 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2021 онд нийт 165,684.8 мянган төгрөгийн 19 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 61,333.8 мянган төгрөгийн 4 мэдээллийг огт байршуулаагүй, 104,351.0 мянган төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газраас итгэл үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албаны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16,267.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 13,881.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 2,385.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага өгч, үндсэн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчилд зөвлөмж өгөв. Мөн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

1.1. Мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн 2,166.8 мянган төгрөгийг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 хавсралтын 6.8-д “Үйл ажиллагааны мөнгөн орлого”-д төсвөөс авсан шилжүүлгийн орлого, төсөвт байгууллагын төлбөртэй ажил үйлчилгээний орлого, тусламжийн орлого зэрэг орох бөгөөд ...”, “үнэн зөв байдал”, “тодруулга ба толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэлт санхүүжилтийн 2,166.8 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн үйл ажиллааны орлогоор бүртгэн залруулсан.

1.2. Үнэ төлбөргүй шилжин ирсэн 11,715.0 мянган төгрөгийн газрыг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор бүртгээгүй, Засгийн газрын сан дансанд бүртгэн тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 6 зүйлийн 6.3.2 д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “тодруулга ба толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үнэ төлбөргүй шилжин ирсэн 11,715.0 мянган төгрөгийн өртөгтэй газрын дүнгээр Засгийн газрын сан дансыг бууруулан Санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор бүртгэн залруулсан.

4.2 Албан шаардлага

Нийт 8 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 2,385.9 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг

хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалт, “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 17 ширхэг 35,659.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1-д “Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон”, “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст нийт 165,684.8 мянган төгрөгийн 19 мэдээллийг ил тод байршуулахаас 61,333.8 мянган төгрөгийн 4 мэдээллийг ил тод байршуулаагүй, 104,351.0 мянган төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|-------------------|-----------|-----------|----------|---------------|-----|-----------------|---------|---------|-----------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн |
| 1 | Үнэ төлбөргүй шилжин ирсэн хөрөнгийг Засгийн газрын сан дансанд тайлагнасан | 1 | 11,715.0 | 1 | 11,715.0 | | | | | | |
| 2 | Нэмэлт санхүүжилтийг мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй | 1 | 2,166.8 | 1 | 2,166.8 | | | | | | |
| 3 | Анхны өртгөөрөө элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. | 1 | - | | | | | | | 1 | - |
| 4 | Худалдан авалт И баримтаар нотлогдоогүй | 1 | 2,385.9 | | | | | 1 | 2,385.9 | | |
| | Дүн | 4 | 16,267.7 | 2 | 13,881.8 | - | - | 1 | 2,385.9 | 1 | - |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал: | | | | | | | | | | | |
| 1 | Шилэн дансны зарим мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроож байршуулсан | 1 | 165,684.8 | - | - | - | - | - | - | 1 | 165,648.8 |
| 2 | Дүн | 1 | 165,684.8 | - | - | - | - | - | - | 1 | 165,648.8 |
| | Нийт дүн | 5 | 181,952.5 | 2 | 13,881.8 | - | - | 1 | 2,385.9 | 2 | 165,684.8 |